

“Ремикон” ХХК-иас нийтэд санал болгон гаргах
үнэт цаасыг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.7 дахь заалт, Хорооны 2006 оны 37 дугаар тогтоолоор баталсан “Нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг бүртгэх тухай журам”-ын 3.1 дэх заалт болон “Ремикон” ХХК-иас ирүүлсэн хүсэлтийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.“Ремикон” ХХК-иас үнэт цаасны зах зээлд нийтэд санал болгон гаргах 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 127 642 623 ширхэг энгийн хувьцааг үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/, Хөрөнгийн биржийн бүртгэлд бүртгэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Р.Содхүү/, төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д тус тус зөвшөөрсүгэй.

2.Хөрөнгө оруулагчдад шийдвэр гаргахад нь шаардлагатай хууль тогтоомжид заасан мэдээллийг нийтийн хүртээл болгосны үндсэн дээр үнэт цаасны анхдагч зах зээлд хувьцаагаа арилжихыг “Ремикон” ХХК /Х.Ганхуяг/, “Ди Си Эф” ХХК /С.Ариунзул/-д тус тус үүрэг болгосугай.

3.Компанийг үүсгэн байгуулагч Х.Ганхуягийн эзэмших 11 857 000 ширхэг энгийн хувьцааг түүний нэр дээр төвлөрсөн хадгаламжид данс нээн байршуулах, уг хувьцааг хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш 6 сарын хугацаанд тусгаарлахыг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д даалгасугай.

4.Х.Ганхуягийн нэмж оруулах 1 633 426 250 төгрөгийн хөрөнгө оруулалт буюу нийт гаргасан хувьцааны 12.84 хувь /16 334 262 ширхэг энгийн хувьцаа/-тай тэнцэх хэмжээний тоног төхөөрөмжүүдийг Компанийн тухай хуулийн 45 дугаар зүйлд заасны дагуу уг тоног төхөөрөмжийг бүрэн хүлээн авсны дараа Хороонд хандаж шийдвэрлүүлэхийг “Ремикон” ХХК /Х.Ганхуяг/, “Ди Си Эф” ХХК /С.Ариунзул/-д тус тус даалгасугай.

5.Энэ тогтоолын 4 дэх заалтад заасан тоног төхөөрөмжүүдээр хийх 16 334 262 ширхэг энгийн хувьцааны төлбөрийг 2008 оны 10 дугаар сард багтаан хийж гүйцэтгэхийг “Ремикон” ХХК (Х.Ганхуяг)-д үүрэг болгосугай.

6.Энэ тогтоолын 4 дэх заалтад дурдсан “Ремикон” ХХК-ийн 16 334 262 ширхэг энгийн хувьцааны төлбөрийг хөрөнгөөр хийх хүртэл компанийн нэр дээр байршуулахыг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/, “Ди Си Эф” ХХК /С.Ариунзул/-д тус тус үүрэг болгосугай.

7.Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлэн ажиллах, нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг бүртгэсэнтэй холбогдуулан зохих баримт бичгүүдэд өөрчлөлт оруулан Үндэсний татварын ерөнхий газрын харъяа Улсын бүртгэлийн албанд бүртгүүлэн ажлын 10 хоногийн дотор Хороонд ирүүлэхийг “Ремикон” ХХК (Х.Ганхуяг)-д үүрэг болгосугай.

8.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийгэд сурталчлан ажиллахыг Үнэт цаасны газар (Х.Бум-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ